



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/310

Улаанбаатар хот

Аргачлал, заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.10, 25.2, Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 124 дүгээр тушаалаар батлагдсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам”-ын 2.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах аргачлал, заавар”-ыг хавсралтын ёсоор баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (онцгой байдлын хурандаа Д.Жаргалмөнх)-т үүрэг болгосугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 205 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн
А/310 дугаар тушаалын хавсралт

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА САЛБАР
НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГАЧЛАЛ, ЗААВАР**

Нэг. Зорилго.

1.1. Төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомж, байгууллагын хэтийн болон тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтыг хангах чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгж, дэргэдэх салбар, орон нутаг дахь салбар, нэгжийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажил үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр нөлөө, бүтээмжийг дээшлүүлэх, үр дүнг үнэлэх, Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 124 дүгээр тушаалаар батлагдсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам”-ыг хэрэгжүүлэхэд энэхүү аргачлал, зааврын зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ, бодлого.

2.1. Онцгой байдлын ерөнхий газрын орон нутаг дахь салбар, нэгжийн үйл ажиллагаанд:

- Удирдлага зохион байгуулалт, дотоод үйл ажиллагаа
- Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа
- Санхүүгийн үйл ажиллагаа
- Улсын нөөцийн салбарын үйл ажиллагаа чиглэлээр хяналт шалгалт

явуулна

2.2. Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгж, дэргэдэх салбар нэгжийн үйл ажиллагааг үндсэн чиг үүрэг, тухайн нэгжийн жилийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны онцлогийг харгалзан шалгуур үзүүлэлтийг тодорхойлж удирдамжийн дагуу шалгана.

Гурав. Үр дүнг үнэлэх аргачлал.

3.1. Биелэлтийн хувь, чанар, дундаж оноог тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

3.1.1. Тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр, үр дүн гарч, тогтворжсон бол 100 хувь;

3.1.2. Тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь

гарч эхэлж байгаа бол 90.0 хувь /80.0-100.0 хүртэл хувь/;

3.1.3. Тавьсан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэр гарсан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь / 60.0-80.0 хүртэл хувь/;

3.1.4. Тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийж байгаа ажлын түвшинг харгалзан 50.0 хувь /40.0-60.0 хүртэл хувь/;

3.1.5. Тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол ажлын түвшинг харгалзан 30 хувь /20.0-40.0 хүртэл хувь/;

3.1.6. Тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангах арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувь /0-20.0 хүртэл хувь /;

3.1.7. Тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийн хувийг "0" гэж дүгнэнэ.

3.2. Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгж, харьяа анги, байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээ нь үзүүлэлт бүрийн үнэлгээний онооны нийлбэрийг үзүүлэлтийн тоонд хувааж гаргасан дундаж оноогоор илэрхийлэгдэнэ.

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулаад өгсөн үнэлгээний нийт оноог үндэслэн дор дурдсан үнэлгээгээр дүгнэнэ.

90-100 оноо "А" буюу "Маш сайн"

80-89,9 оноо "В" буюу "Сайн"

70-79,9 оноо "С" буюу "Хангалттай"

60-69,9 оноо "D" буюу "Дутагдалтай"

0-59,9 оноо "F" буюу "Хангалтгүй"

Дөрөв. Хяналт шалгалт явуулах аргачлал, заавар.

4.1. Хяналт шалгалтын нэгдсэн дүнг дор дурдсан байдлаар гаргана.

№	Үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо
---	---	------------------	------------

4.1.1	Удирдлага зохион байгуулалт, дотоод үйл ажиллагаа	0-15	
-------	---	------	--

4.1.2	Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	0-15	
-------	--	------	--

4.1.3	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	0-40	
-------	----------------------------------	------	--

4.1.4	Санхүүгийн үйл ажиллагаа	0-15	
-------	--------------------------	------	--

4.1.5	Улсын нөөцийн салбарын үйл ажиллагаа	0-15	
-------	--------------------------------------	------	--

Нийт оноо 0-100

4.2. Орон нутаг дахь салбар, нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулахдаа дараах аргачлал, шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт шалгалт явуулж дүгнэнэ.

4.2.1 Удирдлага зохион байгуулалт, дотоод үйл ажиллагаа

№	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо	Хувь, чанар
	Дундаж оноо, хувь			

4.2.1.1 Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг тушаал, шийдвэр Хууль тогтоомжийн хэрэгжилт 0-15
Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах чиглэлээр гарсан төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт 0-15
Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах чиглэлээр олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт 0-15 Монгол Улсын Засгийн газрын тогтоол, шийдвэр, Шадар сайдын тушаал, албан даалгаврын хэрэгжилт, үр дүн 0-15
Онцгой байдлын ерөнхий газрын даргын удирдамж, тушаал, албан даалгаврын хэрэгжилт, үр дүн 0-15
Орон нутгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн биелэлт 0-15
Нэгжийн даргын тушаалын биелэлт 0-15
Нэгжийн хэмжээнд боловсруулж баталсан журам, заавар, санамж бичиг, төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн 0-15

4.2.1.2 Тухайн жилд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт ОБЕГ-ын тухайн онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө түүний биелэлт 0-15
Нэгжээс тухайн жилд дэвшүүлсэн зорилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ 0

4.2.1.3 Үйл ажиллагааны төлөвлөлт
Нэгжийн үйл ажиллагааны хэтийн (бизнес) төлөвлөгөө 0-15
Нэгжийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт 0-15
Орон нутгийн бүх шатны гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөлт, тодотгол хийсэн байдал 0-15
Нэгжийн сар, улирлын төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт 0-15
Тушаал, шийдвэрийн боловсруулалт, хэрэгжилт 0-15

4.2.1.4 Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ
Байгууллагын менежерээс төсвийн ерөнхий менежертэй байгуулсан гэрээний биелэлт 0-15
Нэгжийн менежер, төрийн албан хаагчидтай байгуулсан үр дүнгийн гэрээ, гэрээг дүгнэсэн байдал 0-15
Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, тусгасан зорилт, шаардлага, шалгуур үзүүлэлт 0-15

4.2.1.5 Хүний нөөцийн бүртгэл судалгаа
Албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөн 0-15
Хувийн хэргийн хадгалалт, хамгаалалт 0-15
Бие бүрэлдэхүүний шагнал урамшуулал, сайшаал, шийтгэл, тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн тоо бүртгэл хөтлөлт 0-15
Мэдээ тайлангийн гүйцэтгэл 0-15

4.2.1.6 Албан хаагчдын сахилга, албаны зохион байгуулалт
Нэгжийн сахилга, ёс зүйн албаны үйл ажиллагаа 0-15
Албан хаагчдын цэргийн хэргийн мэдлэг, цэрэгжилт, жагсаалч байдал 0-15
Албан хаагчдын хоорондын харилцаа, захирах, захирагдах ёс 0-15
Сахилгын зөрчлийг илрүүлж шийдвэрлэсэн байдал, судалгаа 0-15
Албан хаагчдийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ 0-15

Байгууллагын дотоод албаны зохион байгуулалт, албаны өрөө, тасалгааны тохижилт, соёлжилт байдал, дэг журам 0-15

Сургалтын талбайн зохион байгуулалт, тохижилт, аюулгүй байдал 0-15

4.2.1.7 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

Эмч-сэтгэл зүйч, эмнэлгийн зааварлагчийн үйл ажиллагаа, ажлын үр дүн 0-

15ОБАЭБ-ын албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах дэд хөтөлбөрийн хэрэгжилт 0-15

Эрүүл мэндийн үзлэг, оношлогоо зохион байгуулсан байдал 0-15

4.2.1.8 Архив, албан хэрэг хөтлөлт

Байгууллагын удирдлагын албан хэрэг хөтлөлтийн байдал 0-15

Архив, бичиг хэргийн хадгалалт 0-15

Баримт бичгийг бүрдүүлсэн байдал, шийдвэрлэлтэд тавих хяналт зохион байгуулалт 0-15

Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх зааврын хэрэгжилт 0-15

Тамга, тэмдэг түших болон хэвлэмэл хуудас хариуцах албан тушаалтныг тушаалаар томилсон байдал 0-15

Архив, албан хэрэг хөтлөлтийн цахим программ суулгаж, ашигласан байдал 0-15

Ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдол, тушаалын дугаарын бүртгэлийн дэвтрүүдийг зааврын дагуу бүрэн хөтлөх, хяналт тавих 0-15

Тогтоол, шийдвэр, тушаал, захирамжинд хяналтын карт, хариутай бичиг, өргөдөл гомдолд бүртгэл хяналтын карт хөтөлж, бүртгэлээр хяналт тавих 0-15

4.2.1.9 Хугацаат мэдээ тайлан.

Хугацаатай үүрэг, даалгаврын биелэлт, тайлагналт 0-15

ОБЕГ-т ирүүлвэл зохих хугацаат мэдээ, тайлангийн хугацаа, бодит байдал 0-15

4.2.1.10 Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлт

Албан хаагчид, иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хяналтанд авч шийдвэрлэсэн байдал 0-15

4.2.1.11 Орон нутгийн Онцгой комиссын ажил

Гамшгаас хамгаалах чиглэлээр Онцгой комиссоор хэлэлцүүлсэн асуудал, шийдвэрлэсэн байдал, үр дүн 0-15

Онцгой комиссын шийдвэр, тэдгээрийн биелэлт 0-15

Хурлын тэмдэглэлийг албажуулсан байдал 0-15

Дундаж оноо 0-15

4.2.2. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

№ Шалгуур үзүүлэлт

Авбал зохих оноо Авсан оноо Хувь, чанар

Дундаж оноо, хувь

4.2.2.1 Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр

Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг Засаг даргын нөөцөд суулгаж, дэмжлэг авч байгаа байдал 0-15

Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр аймаг, сумын Засаг даргын шийдвэр гаргуулж, хэрэгжүүлсэн байдал 0-15

Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тухайн жилд гарсан Монгол улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажилласан байдал 0-15

Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр өгсөн хугацаатай үүрэг даалгаварын биелэлт 0-15

Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сар, улирал, хагас бүтэн жилээр ирүүлэх тайлан мэдээ 0-15

Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ /өдөрлөг, уулзалт бусад / 0-15

Олон улсын болон төрийн бус олон нийтийн байгууллагатай гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран зохион байгуулсан арга хэмжээ / сургалт бусад/ 0-15

Ontsgoi.sur.mn цахим хуудсанд сургалтын мэдээ, материал, хичээл оруулж, цахимаар олон нийтэд сургалт сурталчилгаа явуулсан байдал 0-15

Анги байгууллагын сургалтын танхимын тохижилт 0-15

4.2.2.2 Мэдээлэл сурталчилгаа Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах, түүний хэрэгжилтийг хангах 0-15

Орон нутгийн телевизд болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны тогтмол цагтай болж,гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ТВ хичээл, нэвтрүүлэг явуулсан байдал 0-15

Тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг ухуулах хуудас тараах материал зэрэг мэдээлэл сурталчилгааны архивтай болсон байдал 0-15

Орон нутгийн сонинд гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр цуврал хичээл, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгаа байршлуулах булан нээж, тогтмол ажиллуулсан байдал 0-15

Олон нийт рүү чиглэсэн гамшгаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг сурталчилгааг зохион байгуулах шинэлэг арга барилыг ашигласан байдал 0-15

Аюулт үзэгдэл ослын төрлөөр тараах материал, хэвлүүлж, сурталчилгаа мэдээлэл явуулсан байдал 0-15

Тухайн орон нутагт тохиолдсон аюулт үзэгдэл, ослын талаарх дүрс бичлэг, гэрэл зургийн архив үүсгэх 0-15

Байгууллагын вэб сайтыг шинэчлэх мэдээллийн баяжилтыг тогтмол хийх. 0-15

4.2.2.3 Гамшгаас хамгаалах ангилалын сургалт

Удирдах бүрэлдэхүүний сургалт 0-15

Мэргэжлийн ангийн сургалт 0-15

Ажилчин, албан хаагчийн сургалт 0-15

Оюутан, сурагчдын сургалт 0-15

Ард иргэдийн сургалт 0-15

Гамшгаас хамгаалах иж бүрэн болон удирдах бүрэлдэхүү-ний сургууль Сум, дүүргийн иж бүрэн сургууль 0-15

Сум, дүүргийн команд штабын сургууль 0-15

Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, аж ахуйн нэгж байгууллагын команд штабын сургууль 0-15

4.2.2.4 Хичээлийн конспект бэлтгэх

Гамшгаас хамгаалах менежментийн чиглэлээр 0-15

Хууль эрх зүйн чиглэлээр	0-15
Аюулт үзэгдэл, ослын төрлөөр	0-15
Соён гэгээрүүлэх чиглэлээр	0-15
4.2.2.5 Бие бүрэлдэхүүний сургалт	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө
боловсруулж батлуулсан байдал	0-15
Сургалтын төлөвлөгөөний үйл ажиллагааны хэрэгжилт, тайлан мэдээ	0-15
Офицер бүрэлдэхүүний	0-15
Ахлагч бүрэлдэхүүний	0-15
Энгийн албан хаагчдын	0-15
Гал унтаах аврах анги	
Тактикийн сургууль	0-15
Тархалтын сургууль	0-15
Өдөр тутмын сургууль	0-15
Аврах анги	
Хээрийн гаралт	0-15
Аврах ажиллагааны өдөр тутмын	0-15
Хууль, эрх зүйн тестийн шалгалт	0-15
Бие бялдарын шалгалт	0-15
Соёл хүмүүжлийн арга хэмжээ	0-15
Дундаж оноо	0-15

4.2.3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа

№ Шалгуур үзүүлэлт

Авбал зохих оноо Авсан оноо Хувь, чанар

Дундаж оноо, хувь

Гамшгийн хор уршгийг арилгах чиглэлээр.

4.2.3.1 Гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангах төлөвлөлт Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нэгдсэн судалгаа /5-аас дээш жилээр/ 0-40

Дайчилгаагаар ажиллах хүч, хэрэгслийн томилгоожуулалт, баталгаажуулалт 0-40

Бүх шатны гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн нөөц бүрдүүлэлт 0-40

Орон нутгийн удирдлагатай ажлаа уялдуулж, дэмжлэг авч байгаа байдал 0-40

Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын бэлтгэл, бэлэн байдал, хамтын ажиллагаа 0-40

Зарлан мэдээлэх болон яаралтай цуглар дохиогоор ажиллаж байгаа байдал /хувь хүний бэлтгэл, бэлэн байдал/ 0-40

Гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгаа, сэрэмжлүүлэг, мэдээллийг шуурхай хүргэсэн байдал, үр дүн 0-40

Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан байдал 0-40

Зэргэлдээ аймагтай харилцан ажиллах төлөвлөгөө, түүний хэрэгжилт 0-40

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр заавар, зөвлөмж өгч ажилласан байдал 0-40

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр өгсөн заавар, зааварчилгаа, зөвлөмж, баталгаажуулалт 0-40

Дундаж оноо 0-40

4.2.3.2 Гамшиг, аюулт үзэгдэл, ослын хор уршгийг арилгах

Гамшиг аюулт үзэгдэл, ослын хор уршгийг арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ 0-40

Орон нутгийн удирдлага, гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангиудтай хамтран ажилласан байдал 0-40

Үүссэн нөхцөл байдлын хор уршгийг арилгах үйл ажиллагааг өөрсдийн хүч хэрэгслээр зохион байгуулсан эсэх 0-40

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлагын бүртгэл, удирдлагыг мэдээллээр шуурхай хангах үйл ажиллагаа 0-40

Удирдлагаас гаргасан шийдвэр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ 0-40

Гамшгийн голомтод ажилласан талаарх тайлан 0-40

Дундаж оноо 0-40

4.2.3.3 Аврах анги, салбарын үйл ажиллагаа Анги салбарын сар, улирал, жилийн төлөвлөгөөний биелэлт 0-40

Аврах ажлын чиглэлээр батлагдсан дүрэм, журам, зааврын хэрэгжилт /хими, цацраг, усны г.м/ 0-40

Анги салбарын сургалт соёл хүмүүжилийн ажил 0-40

Жижүүр, ээлжийн бүрэлдэхүүн машин техник, багаж хэрэгсэлийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж илэрсэн дутагдалыг арилгуулж бэлэн байдлыг хангасан талаар 0-40

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил 0-40

Эмнэлгийн анхан шатны багаж хэрэгсэл, эм тарианы нөөц, үүрэг гүйцэтгэх бэлтгэлийг хангасан байдал 0-40

Гамшгийн голомтод бие бүрэлдэхүүнийг удирдаж, газар дээр нь удирдлагаар хангаж ажилласан талаар 0-40

Гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах дадлага сургуулийг зохион байгуулсан талаар 0-40

Зарлан мэдээлэх болон яаралтай цуглар дохиогоор ажилласан байдал /хувь хүн, бүлэг салбар, ангиар/ 0-40

Техник багаж хэрэгсэлийн бэлтгэл бэлэн байдлыг шалгасан эсэх /өдөр бүр, 7, 14 хоног, сар, улирал/ 0-40

Гамшгийн голомтод ажилласан байдлыг баримтжуулсан байдал /газрын зурагт оруулах/ 0-40

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөтэй эсэх тодотгол томилгоог цаг хугацаанд нь хийсэн байдал 0-40

Албан хаагчдын хаягийн бүртгэл, тодотголыг хийсэн байдал 0-40

Аюулт үзэгдэл ослын үед үүрэг гүйцэтгэж буй бүлгийн ар тал хангалтын асуудлыг зохион байгуулсан талаар 0-40

Анги, салбарын дотоод дэг журам, сахилга хариуцлага, цэрэгжилч, жагсаалч байдал 0-40

Хоногийн ээлж болон харуул манаанд үүрэг гүйцэтгэлийн талаар 0-40

Дундаж оноо 0-40

4.2.3.4 Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх

Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажилд орон нутгийн төр захиргааны байгууллагаас тодорхой шийдвэр гаргуулан, бодит дэмжлэг туслалцаа авч ажилласан байдал 0-40

Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг дүүрэг сумдад зохион байгуулах талаар удирдлага арга зүйгээр хангаж ажилласан байдал 0-40

Галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг олон төрөл хэлбэр ашиглан явуулсан болон түүнд нийт бие бүрэлдэхүүнийг хамруулсан байдал 0-40

Гэр хороолол бүхий хороонд галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн 0-40

4.2.3.5 Гал түймэр унтраах ангийн үйл ажиллагаа

Гал унтраах, аврах ангийн жил, улирал, сарын үйл ажиллагааны төлөвлөгөө 0-40

Алба хаагчийн үр дүнгийн гэрээ, түүний биелэлт, үнэлгээ 0-40

Гал унтраах аврах ангийн бие бүрэлдэхүүнд хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны болон гал түймэр унтраах дүрэм, хорт хий утаанаас хамгаалах дүрэм болон холбогдох эрх зүйн бичиг баримтуудыг судлуулж, сургалт явуулан улирал тутам шүүлэг авсан байдал 0-40

Гал унтраах дасгал сургуулийн нормативаар улирал тутамд шүүлэг авсан байдал. 0-40

Салаадын захирагчийн сар бүрийн ажлыг дүгнэсэн байдал 0-40

Улсын онц чухал объектын зам гарц, усан хангамжийн судалгаа 0-40

Гал түймэр унтраах аврах ангийн үйлчлэх хүрээний зураг бүдүүвч, судалгаа, хамгийн алслагдсан цэгт байрлах объект, айл өрхөд хүрэлцэн очих маршрут, зам гарц, зарцуулах хугацааны тодорхойлолт (шуурхай албаны автомашин хүрэлцэн очих боломжгүй болон саад ихтэй газрууыг орон нутгийн удирдлагад танилцуулж шийдвэрлүүлсэн байдал) 0-40

Гал түймэр унтраасан нотломж, гал түймрийн дуудлагаар ажилласан бүртгэл 0-40

Гал унтраах 3-н шатны дасгал сургууль /тактик, тархалтын, өдөр тутмын/ 0-40

Удаан хугацаагаар болон олон тасаг ажилласан, хүн өртөж нас барсан гал түймэр унтраасан тухай ярилцлага зохион байгуулсан байдал 0-40

Гал унтраах зориулалтын автомашин болон гал түймэр унтраах багаж зэвсэглэмжид хийгдсэн засвар үйлчилгээ, ХХАА-ны шаардлагын дагуу шалгалт хийсэн тэмдэглэл 0-40

Гал түймэр унтраах аврах ангийн хүчин чадлын мэдээ 0-40

Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, түүний баяжилт 0-40

Бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг өсөн нэмэгдүүлэх талаар авсан арга хэмжээ. /Уралдаан тэмцээн зохион байгуулсан/ 0-40

Зарлан мэдээлэх болон яаралтай цуглар дохиогоор ажилласан байдал, цугларалтын схем бүдүүвч, хаягын тодотгол, утасны жагсаалт, дохиогоор ажиллах төлөвлөгөө 0-40

Дундаж оноо 0-40

4.2.3.6 Гал унтраах, аврах ангийн салааны захирагчийн үйл ажиллагаа
Салааны албан хаагчдын ажил дүгнэсэн үзүүлэлт 0-40

Гал түймэр унтраах дүрэм, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны болон хорт хий утаанаас хамгаалах талаар дагаж мөрдөх дүрмүүдээр авсан шалгалт, шүүлэг 0-40

Гал түймрийн дуудлагаар ажилласан бүртгэл, ярилцлага 0-40

Албан хаагч нэг бүртэй ажилласан тэмдэглэл. 0-40

Мэргэжлийн болон хууль эрх зүйн хичээл явуулсан конспект, бүртгэл 0-40
Хариуцсан хороо, багийн ерөнхий болон зам гарц, усан хангамжын схем зураг, 0-40

Зарлан мэдээлэх болон яаралтай цуглар дохиогоор ажилласан байдал, цугларалтын схем бүдүүвч, хаягын тодотгол, утасны жагсаалт, дохиогоор ажиллах төлөвлөгөө 0-40

Дундаж оноо 0-40

№ Шалгуур үзүүлэлт

Авбал зохих оноо Авсан оноо Хувь, чанар

Дундаж оноо, хувь

Гал түймрийн улсын хяналтын чиглэлээр

4.2.3.7 Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хувийн дугаар бүхий баталгааны тэмдэг, энгэрийн тэмдэг, шалгах эрхийн үнэмлэх зэргийн ашиглалт 0-40

Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн нэгдсэн удирдамж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтын материал, тайлан мэдээ 0-40

Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн авсан захиргааны арга хэмжээ, үндэслэл, бүртгэл 0-40

Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн эрх зүйн баримт бичгийн боловсруулалт 0-40

Өргөдөл гомдол, гал түймрийн хэрэг зөрчлийн шийдвэрлэлт, акт тэмдэглэл хөтлөлт 0-40

Гарсан гал түймрийн нөхцөл байдлын тухай мэдээ, мэдээлэл (дээд шатны болон орон нутгийн төр захиргааны байгууллагад танилцуулах мэдээ сар бүр) 0-40

Улсын онц чухал болон галын аюултай объектуудын бүртгэл, судалгааг тогтмол шинэчилж, гал түймрийн улсын хяналтын шалгалтыг явуулахдаа шаардлагатай тооцоо судалгаа, баримт бичгийг гаргуулан авч үзлэг шалгалтыг урьдчилсан бэлтгэлтэйгээр зохион байгуулсан байдал 0-40

Гал түймрийн улсын хяналтын заавал биелүүлэх албан шаардлага, мэдэгдлийн хариуг авч үр дүнг тооцсон байдал 0-40

Барилга байгууламжийн зураг төсөлд хяналт хийсэн болон байнгын ашиглалтад оруулах комисст ажилласан талаар материал /тэмдэгтийн хураамжийн төлбөр/ 0-40

Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвшөөрөл олгох, дүгнэлт гаргах журмын хэрэгжилт 0-40

Объектын хувийн хэрэг, гал унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулах, шинэчлэх, тодотгоход Гал унтраах, аврах ангитай хамтарч ажилласан байдал 0-40

Дундаж оноо 0-40

Техникийн бэлтгэл бэлэн байдлын чиглэлээр

4.2.3.8 Техник, багаж хэрэгслийн бэлэн байдал, хадгалалт, хамгаалалт Гал унтраах, Аврах ажлын зориулалттай автомашин техникийн ашиглалт, бэлэн байдал 0-40

Гал түймэр унтраах, Аврах ажлын зориулалттай багаж, тоног төхөөрөмж, зэвсэглэмжийн ашиглалт, бэлэн байдал 0-40

Техник хэрэгслийн ашиглалтын дэвтэр хөтлөлт, гэмтэл, саатлын бүртгэл, засвар үйлчилгээ хийсэн байдал 0-40

Гал унтраах, Аврах ажлын техник, багаж тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалтын байдал 0-40

Хүч хэрэгслийн чадавхийг дээшлүүлэх талаар зохион байгуулсан ажил, арга хэмжээ 0-40

Дундаж оноо 0-40

Холбоо зарлан мэдээллийн чиглэлээр

4.2.3.9 Холбоо мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдал, төлөвлөлт Холбоо зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалт, хадгалалтын байдал 0-40

Автомашинд суурилагдсан радио станцын ашиглалт, антен-фидерийн байгууламжийн техник үйлчилгээний байдал 0-40

Сансрын холбооны радио станцын ашиглалтын байдал 0-40

Интернэтийн сүлжээний хурд, түүнд холбогдсон компьютерын техникийн үзүүлэлт, ашиглалтын байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байдал 0-40

Үүрэг гүйцэтгэхээр томилогдсон бүлэгтэй радио холбоо тогтоосон байдал, сонсголын чанар 0-40

Гамшгийн үед бусад байгууллагуудтай харилцан ажиллах үеийн холбоо зохион байгуулах төлөвлөгөө, түүний дагуу дадлага сургууль хийсэн байдал 0-40

4.2.3.10 Гамшгийн аюулын зарлан мэдээлэл Гар утасны хэрэглэгчид мессеж хэлбэрээр дамжуулсан байдал 0-40

Орон нутгийн телевизээр дамжуулсан байдал 0-40

Орон нутгийн FM радиогоор дамжуулсан байдал 0-40

Гамшиг аюулыг анхааруулах төхөөрөмж/ чанга яригч, серень/-ний дуугаралт хүн амыг нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн хамрах хэмжээнд байгаа эсэх, ашиглалт, хамгаалалтын байдал 0-40

4.2.3.11 Үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилт Радио холбооны журналын хөтлөлт, холбоонд орсон бүртгэл 0-40

Холбоо мэдээллийн ажлын төлөвлөлт, түүний биелэлт, тайлан мэдээ 0-40

Радио станцын батарейны цэнэглэлтийн бүртгэл, ашиглалтын нөөцийг тооцсон байдал 0-40

Холбоо мэдээллийн техник хэрэгслийн бүртгэл, судалгаа, эдэлгээний хугацааг тооцсон байдал 0-40

Техник хэрэгслийн ашиглалтын дэвтэр хөтлөлт, гэмтэл саатлын бүртгэл, засвар, техникийн үйлчилгээ хийсэн байдал 0-40

4.2.3.12 Мэргэжил, дадлагажсан байдал Холбоо мэдээллийн техник хэрэгслийг ашиглах талаар бие бүрэлдхүүнтэй сургалт явуулсан байдал 0-40

Дуудлага хүлээн авагч нарын ажлын үзүүлэлт, радио холбооны сахилга батыг хангаж байгаа байдал 0-40

Холбоо мэдээллийн мэргэжилтэн, дуудлага хүлээн авагч нарын мэргэжил ажлын байрны тодорхойлолтонд заасан үзүүлэлтийг хангаж байгаа эсэх 0-40

Холбоо зарлан мэдээллийн мэргэжилтний ажил, үүргийн гүйцэтгэлийн байдал 0-40

Дуудлага хүлээн авагчийн хөтөлбөл зохих баримт бичиг /Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 12 тоот тушаал/ 0-40

Дундаж оноо 0-40

4.2.4. Санхүүгийн үйл ажиллагаа

№ Шалгуур үзүүлэлт

Авбал зохих оноо Авсан оноо Хувь, чанар

Дундаж оноо, хувь

4.2.4.1 Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл

Төсөвт зардлын бодит үндэслэл, төлөвлөлт, 0-15

Өр авлагын барагдуулалт 0-15

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний бодит үндэслэл, төлөвлөлт, биелэлт 0-15

4.2.4.2 Нягтлан бодох бүртгэл

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн боловсруулж, батлуулан хэрэгжүүлж буй байдал 0-15

Анхан шатны баримт хөтлөлт, иж бүрдэл, үдэлт, цэгцлэлт

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа 0-15

Санхүүгийн мэргэжлийн болон хяналт шалгалтын байгууллагуудаас гаргасан шийдвэр, өгсөн үүргийн биелэлт 0-15

Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл, үндсэн хөрөнгийн ашиглалт, чанар байдал 0-15

Агуулахын эмх цэгц, бараа материалын хадгалалт, хамгаалалт, агуулахын бүртгэл, нягтлан бодогчийн баталгаажуулалт 0-15

Няравын тайлан, тооцоо бодсон акт 0-15

4.2.4.3 Цалин хөлс тогтоолт, бодолт, олголтын үндэслэл, тооцоог хянаж үнэлэх

Албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, бодолт, олголт, гэрээт ажиллагсадтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн хөлс олголт 0-15

Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээний хугацаат чанар, үнэн зөв байдал 0-15

Нягтлан бодох бүртгэлийн хагас, бүтэн жилийн тайлан аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт 0-15

4.2.4.4 Нягтлан бодогчийн мэргэжлийн болон ажил гүйцэтгэх ур чадвар Нягтлан бодох бүртгэлийн мэдлэг, чадвар /тестээр/ 0-15

Шинэлэг арга барил, бүтээлч санаачилга 0-15
mta.mn, nd.8.ndaatgal.mn сайтууд болон, Шилэн дансны хуулийн хэрэгжилт (shilendans.gov.mn), эрүүл мэндийн дэвтэрийн баталгаажуулалт 0-15

Үнэт цаасны тооцоонд хяналт тавих. 0-15

Санхүүгийн Acolous, Pyaroll программын ашиглалт, эзэмшилт 0-15

4.2.4.5. Байгууллагаа тохижуулах, ажиллах нөхцлийг сайжруулах арга хэмжээг зохион байгуулсан байдал

Өөрийн дотоод нөөц бололцоо, орон нутгийн дэмжлэгэд тулгуурлан байгууллагын тохижилт, албан хаагчдын ажиллах нөхцөл, багаж хэрэгслийн хангалт, засвар үйлчилгээг сайжруулах талаар хийсэн ажил, үр дүн нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ 0-15

4.2.4.6. Хувцас, багаж хэрэгслийн хангалт Албан хаагчдын дүрэмт болон ажлын тусгай хувцасны хангалт, ашиглалт, аврах багаж хэрэгслийн хангалт 0-15

Дундаж оноо 0-15

4.2.5. Улсын нөөцийн салбарын үйл ажиллагаа

№ Шалгуур үзүүлэлт

Авбал зохих оноо Авсан оноо Хувь, чанар

Дундаж оноо, хувь

4.2.5.1 Хууль тогтоомжийн хэрэгжилт Улсын нөөцийн тухай болон бусад холбогдох хуулийн хэрэгжилт 0-15

Монгол Улсын Засгийн газрын тогтоол болон Шадар сайдын тушаал, шийдвэрийн биелэлт 0-15

Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал, шийдвэрийн биелэлт, үр дүн 0-15

Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын даргын өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилт 0-15

4.2.5.2 Бараа, материалын хадгалалт, зарцуулалт, сэлгэлт, шинэчлэлт Бараа материалын хуваарийн дагуу сэлгэлт 0-15

Бараа материалын зарцуулалт 0-15

Бараа материалын хадгалалт 0-15

4.2.5.3 Агуулахын бэлэн байдал

Агуулахын тоног төхөөрөмжийн хувийн хэрэг, техникийн үнэмлэх хөтлөлт 0-15

- Агуулахын ариун цэвэр, цэвэрлэгээ, эмх цэгц, тохижилт, хаягжуулалт
0-15
- 4.2.5.4 Гал түймрийн аюулгүй байдал Галын аюулаас урьдчилан сэргийлэх
анхан шатны багаж хэрэгслийн бүрдүүлэлт, бэлэн байдал 0-15
- Бараа материалын хураалт (стандарт, аюулгүй байдлын дагуу)
0-15
- Харуул хамгаалалт 0-15
- Улсын нөөцийн бараа материалтай холбоотой өр авлагын
барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ 0-15
- Нийт оноо 0-15

--oOo--